

ТӨСӨЛ
Засгийн газрын 2025 оны ...дугаар
сарын ...-ний өдрийн ...дугаар т
тогтоолын хавсралт

**БАРИЛГЫН МАТЕРИАЛ,
БҮТЭЭГДЭХҮҮНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН
ТЕХНИКИЙН ЗОХИЦУУЛАЛТ**

2025 он

АГУУЛГА

БҮЛЭГ 1. Ерөнхий зүйл

1 дүгээр зүйл. Хамрах хүрээ ба зохицуулалтын зарчим

2 дугаар зүйл. Нэр томъёо, тодорхойлолт

3 дугаар зүйл. Ерөнхий шаардлага ба хэрэглээ

БҮЛЭГ 2. Аюулгүй байдал, хүрээлэн буй орчны шаардлага

4 дүгээр зүйл. Барилгын материал, бүтээгдэхүүний аюулгүй байдлын шаардлага

5 дугаар зүйл. Эрүүл ахуй, хүрээлэн буй орчны хамгаалалтын үндсэн шаардлага

БҮЛЭГ 3. Тохирлын баталгаажуулалт ба шошгожуулалт

6 дугаар зүйл. Тохирлын баталгаажуулалт

7 дугаар зүйл. Барилгын материал, бүтээгдэхүүний сав баглаа, боодол, хаяг, шошгожуулалт

БҮЛЭГ 4. Хариуцлага, буцаан таталт ба хориглолт

8 дугаар зүйл. Хариуцлага, хориглолт ба буцаан таталтын нөхцөл

БҮЛЭГ 5. Хэрэгжилтэд тавих хяналт шалгалт

9 дүгээр зүйл. Хэрэгжилт, хяналт шалгалтын зохицуулалт

БҮЛЭГ 6. Шилжилтийн зохицуулалт

10 дугаар зүйл. Шилжилтийн зохицуулалт

---oOo---

БАРИЛГЫН МАТЕРИАЛ, БҮТЭЭГДЭХҮҮНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ТЕХНИКИЙН ЗОХИЦУУЛАЛТ

БҮЛЭГ 1. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

1 дүгээр зүйл. Хамрах хүрээ ба зохицуулалтын зарчим

1.1. Энэхүү “Барилгын материал, бүтээгдэхүүний аюулгүй байдлын техникийн зохицуулалт” (цаашид “Техникийн зохицуулалт” гэх) нь иргэдийн амь нас, эрүүл мэнд, байгаль орчныг хамгаалах, хэрэглэгчийг төөрөгдүүлэхээс урьдчилан сэргийлэх, түүнчлэн барилгын материал, бүтээгдэхүүний зориулалт, аюулгүй байдлыг хангах үндсэн суурь шаардлагыг тогтооно.

1.2. Улсын гарал үүслээс үл хамааран, барилга байгууламжид ашиглахаар зах зээлд нийлүүлж, хэрэглэж буй барилгын материал, бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах шаардлагыг энэ техникийн зохицуулалтаар зохицуулна.

1.3. Энэ техникийн зохицуулалт нь дараах материал, бүтээгдэхүүнд хамаарахгүй.

1.3.1. Өөрсдийн хэрэгцээнд зориулан үйлдвэрлэсэн;

1.3.2. Үзэсгэлэн, яармаг, сурталчилгааны ажилд зориулж дээж, үзмэр болгон импортолсон;

1.3.3. Үндэсний шаардлагад нийцэж байгаа эсэхийг баталгаажуулах, туршилт, судалгаа хийх зорилгоор дээж, сорьц болгон импортолсон;

1.3.4. Монгол Улсын нутаг дэвсгэрт хэрэглэх зориулалтгүйгээр, гэрээний дагуу гадаадын байгууллагын захиалгаар бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд түүхий эд болгон импортолсон;

1.3.5. Эрдэм шинжилгээ, судалгааны зорилгоор импортолсон;

1.3.6. Гадаад худалдааны гэрээгээр экспортод нийлүүлсэн;

1.3.7. Гадаад улсын дипломат болон консулын төлөөлөгчийн газар, олон улсын байгууллагын төлөөлөгчийн газрын үйл ажиллагааг дэмжих зорилгоор импортолсон.

2 дугаар зүйл. Нэр томъёо, тодорхойлолт

Энэхүү техникийн зохицуулалтад хэрэглэсэн нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно. Үүнд:

2.1. **аюулгүй байдал**-хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгө, хүрээлэн буй орчинд хор хөнөөл учруулж болзошгүй эх үүсвэрээс урьдчилан сэргийлж, таатай нөхцөл баталгаатай хангагдсан байдал;

2.2. **анхдагч туршилт**-энэхүү техникийн зохицуулалт болон холбогдох техникийн норматив, эрх зүйн актуудад тусгасан аюулгүй байдлын шаардлагад нийцэж байгаа эсэхийг баталгаажуулах зорилгоор барилгын материал, бүтээгдэхүүнд итгэмжлэгдсэн лабораториудаас хийсэн нэг буюу хэд хэдэн анхдагч туршилт;

2.3. **барилгын материал**-стандарт, эрүүл ахуй, экологийн шаардлагыг хангасан барилга байгууламжид хэрэглэгдэх эрдэс, түүхий эд, материал, бүтээц, бүтээгдэхүүн, эдлэхүүнийг;

2.4. **барилгын бүтээгдэхүүн**-барилга байгууламж, түүний бүрдэл хэсгүүдэд байнгын байдлаар суурилуулж ашиглах зориулалттайгаар үйлдвэрлэж, зах зээлд нийлүүлсэн, тухайн барилга байгууламжийн үндсэн шаардлагыг хангасан иж бүрдэл

2.5. **буцаан татах**-эцсийн хэрэглэгчид очсон барилгын материал, бүтээгдэхүүнийг буцаахад чиглэсэн үйл ажиллагаа

2.6. **зах зээлд байршуулах** -барилгын материал, бүтээгдэхүүнийг зах зээлд хамгийн анх нэвтрүүлэх үйл ажиллагааг;

2.7. **зах зээлд нийлүүлэх**-барилгын материал, бүтээгдэхүүнийг хэрэглэгчдэд нийлүүлэх үйл ажиллагааг;

2.8. **импортлогч**-гадаадын барилгын материал, бүтээгдэхүүнийг нийлүүлэх худалдааны гэрээ байгуулж, өөрийн орны зах зээлд нийлүүлэхдээ энэхүү техникийн зохицуулалтын аюулгүй байдлын шаардлагыг дагаж мөрдөх үүрэгтэй иргэн, хуулийн этгээд;

2.9. **техникийн баримт бичиг**-Монгол Улсын нутаг дэвсгэрт барилга байгууламж барих болон ашиглах үеийн барилгын материал, бүтээгдэхүүн (импортын материал, бүтээгдэхүүн мөн адил), галын аюулаас хамгаалах болон гал унтраах хэрэгслийг хэрэглэх боломжтой эсэх талаар техникийн дүгнэлт гаргаж, баталгаажуулан тэдгээрийн хэрэглэх хүрээ, нөхцөлийг тодорхойлсон баримт бичиг;

2.10. **техникийн дүгнэлт**- техникийн баримт бичгийг баталгаажуулах цогц ажил бөгөөд энэ нь техникийн зохицуулалтын баримт бичигт заасан аюулгүй байдлын шаардлагуудыг харгалзан хийнэ;

2.11. **үйлдвэрлэгч**-барилгын материал, бүтээгдэхүүнийг үйлдвэрлэж, зах зээлд нийлүүлэн, энэхүү техникийн зохицуулалтын аюулгүй байдлын шаардлагуудыг дагаж мөрдөх үүрэгтэй хуулийн этгээд;

2.12. **үйлдвэрлэгчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч**-гэрээний үндсэн дээр үйлдвэрлэгчийн нэрийн өмнөөс үйл ажиллагаа явуулж тохирлын баталгаатай барилгын материал, бүтээгдэхүүнийг зах зээлд нийлүүлэх эрх бүхий аливаа иргэн, Монгол Улсын хуулийн этгээд;

2.13. **үйлдвэрлэлийн дотоод хяналтын тогтолцоо**-чанарын тогтвортой үзүүлэлт бүхий барилгын материал, бүтээгдэхүүн үйлдвэрлэх чадвараа нотолж үйлдвэрлэгчээс үйлдвэрлэлийн бүх үе шатанд хэрэгжүүлсэн цогц арга хэмжээ;

2.14. **хадгалах хугацаа**- өгөгдсөн хугацаанд зохих нөхцөлийн дагуу хадгалж, хэрэглэхэд тухайн барилгын материал, бүтээгдэхүүний чанар хамгийн сайн түвшинд байх, тухайн хугацаа хэтрэхэд бүтээгдэхүүний аюулгүй байдал нь алдагдахгүй боловч чанарын үзүүлэлт нь өөрчлөгдөх хугацааг;

2.15. **эрсдэл** - хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгө, хүрээлэн буй орчинд учирч болзошгүй аюул, түүний үр дагаврын магадлал;

2.16. **зураасан код**-гэж аливаа бараа, түүхий эд, бүтээгдэхүүнийг тодорхойлох давхардахгүй дугаарыг.

3 дугаар зүйл. Ерөнхий шаардлага ба хэрэглээ

3.1. Барилгын материал, бүтээгдэхүүн нь Барилгын тухай, Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хууль болон холбогдох техникийн зохицуулалт, норм, нормативын баримт бичгээр тогтоосон шаардлагад нийцсэн байна.

3.2. Барилгын материал, бүтээгдэхүүний нэр, төрөл, шинж чанар, аюулгүй байдлын үзүүлэлт, үйлдвэрлэсэн улсын нэр, үйлдвэрлэгчийн нэр, тэмдэг, тэмдэглэгээ, эрх бүхий байгууллагаас олгосон шошгожилтын мэдээлэл бүхий зураасан код эсхүл QR код шууд бүтээгдэхүүн дээр эсхүл түүний савлагаан дээр байрлуулна. Техникийн боломжгүй тохиолдолд уг мэдээллийг дагалдах баримт бичигт тусгана.

3.3. Энэ техникийн зохицуулалтын 3.3-д заасан зураасан код эсхүл QR код байрлуулах бүтээгдэхүүний жагсаалтыг Барилгын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

3.4. Барилгын материал, бүтээгдэхүүнд дагалдуулах баримт бичигт дараах зүйлийг тусгасан байна.

3.4.1. барилгын материал, бүтээгдэхүүний зориулалт, хэрэглэх хүрээний мэдээлэл;

3.4.2. аюулгүй байдлын шаардлагуудыг багтаасан хэрэглээний үндсэн шинж чанар, үзүүлэлтийн талаархи мэдээлэл;

3.4.3. хэрэглэгчийн эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд сөрөг нөлөө үзүүлэх нөхцөл, урьдчилан сэргийлэх арга хэмжээ, аюулгүй хэрэглэх, ашиглах заавар, хадгалах, тээвэрлэх, устгах шаардлага;

3.4.4. үйлдвэрлэгч, түүний итгэмжлэгдсэн төлөөлөгч, импортлогч, экспортлогчийн хаяг, түүнтэй холбоотой мэдээлэл;

3.4.5. барилгын материал, бүтээгдэхүүнд эвдрэл, гэмтэл илэрсэн тохиолдолд авах арга хэмжээний тухай мэдээлэл;

3.4.6. барилгын материал, бүтээгдэхүүнийг үйлдвэрлэсэн огноо.

3.5. Барилгын материал, бүтээгдэхүүн нь аюулгүй байдлын шаардлагад нийцэж хүний эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд сөрөг нөлөөгүй болохыг баталгаажуулсан Тохирлын гэрчилгээтэй байна.

3.6. Тохирлын гэрчилгээ, нийлүүлэгчийн мэдэгдэлтэй барилгын материал, бүтээгдэхүүнийг зах зээлд нийлүүлнэ.

БҮЛЭГ 2. АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧНЫ ШААРДЛАГА

4 дүгээр зүйл. Барилгын материал, бүтээгдэхүүний аюулгүй байдлын шаардлага

4.1. Барилгын материал, бүтээгдэхүүн нь стандарт, норм, нормативын баримт бичигт заасан шаардлага, үйлдвэрлэл, нийлүүлэлт, хэрэглээний аюулгүй байдлыг хангасан байна.

4.2. Барилгын материал, бүтээгдэхүүн нь “Барилга байгууламжийн галын аюулгүй байдлын техникийн зохицуулалт”, “Барилга байгууламжийн аюулгүй байдлын техникийн зохицуулалт”-ын шаардлагад нийцсэн байна.

4.3. Барилгын материал, бүтээгдэхүүн нь эрчим хүчний хэмнэлт, дулаан хамгаалалтын норм, нормативын баримт бичгийн шаардлагад нийцсэн байна.

4.4. Барилгын материал, бүтээгдэхүүнийг дараах тохиолдолд хүний эрүүл мэнд, аюулгүй байдалд сөрөг нөлөөтэй гэж үзнэ. Үүнд:

4.4.1. Барилгын материал, бүтээгдэхүүнд агуулагдах болон түүнийг хэрэглэх явцад хүрээлэн буй орчинд ялгарах хортой бодисын агууламж нь Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөж байгаа стандарт, норматив баримт бичигт заасан зөвшөөрөгдөх хэмжээнээс хэтэрсэн;

4.4.2. Зориулалтын бус үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж, сав, баглаа боодол, тээврийн хэрэгсэл ашигласан;

4.4.3. Үйлдвэрлэл, хадгалалт, нийлүүлэлтийн горим зөрчсөнөөс үйлдвэрлэл, нийлүүлэлтийн сүлжээний дараагийн үе шатанд эрсдэл гаргасан;

4.4.4. Монгол Улсад болон олон улсад бүртгэгдээгүй, хориглосон, эрсдлийн үнэлгээ хийгээгүй, хэрэглэж дуусах хугацаа хэтэрсэн химийн бодис, түүхий эд ашигласан.

5 дугаар зүйл. Эрүүл ахуй, хүрээлэн буй орчны хамгаалалтын үндсэн шаардлага

5.1. Барилгын материал, бүтээгдэхүүн нь хүний эрүүл мэнд, эрүүл ахуй, хүрээлэн буй орчин болон экосистемийн тэнцвэрт байдалд сөрөг нөлөө үзүүлэхгүй байх бөгөөд байгаль орчин, эрүүл ахуйн холбогдох стандарт, норм, дүрмийн шаардлагад нийцсэн байна.

5.2. Үйлдвэрлэгч, түүний итгэмжлэгдсэн төлөөлөгч нь барилгын материал, бүтээгдэхүүний шинж чанар, аюулгүй байдалд сөргөөр нөлөөлөх хүчин зүйлийг илрүүлэн тогтоох, үнэлэн дүгнэх, хянан шалгах зорилгоор дотоод үйл ажиллагаандаа эрсдэлийн үнэлгээг жил тутам хийнэ.

5.3. Барилгын материал, бүтээгдэхүүний чанар, шаардлагыг хянах, туршихдаа холбогдох стандарт, норм, нормативын баримт бичгээр тогтоосон арга, аргачлалыг хэрэглэнэ. Хэрвээ байхгүй бол эрх бүхий байгууллагатай хамтран боловсруулж хэрэгжүүлнэ.

5.4. Барилгын материал, бүтээгдэхүүний хадгалах хугацааг стандартад зааснаар тооцох ба нийлүүлэлтийн сүлжээний бүх үе шатанд материал, бүтээгдэхүүн нь шинж чанар, аюулгүй байдлын үзүүлэлтээ хадгалсан байвал зохино.

БҮЛЭГ 3. ТОХИРЛЫН БАТАЛГААЖУУЛАЛТ БА ШОШГОЖУУЛАЛТ

6 дугаар зүйл. Тохирлын баталгаажуулалт

6.1. Үйлдвэрлэгч, түүний итгэмжлэгдсэн төлөөлөгч, импортлогч нь барилгын материал, бүтээгдэхүүнийг энэхүү техникийн зохицуулалтын аюулгүй байдлын шаардлагад нийцэж байгааг нийлүүлэгчийн мэдэгдэл эсвэл тохирлын гэрчилгээгээр баталгаажуулна.

6.2. Үйлдвэрлэгч, түүний итгэмжлэгдсэн төлөөлөгч, импортлогч нь барилгын материал, бүтээгдэхүүнийг энэхүү техникийн зохицуулалтын аюулгүй байдлын шаардлагад нийцүүлэх арга хэмжээг авах үүрэгтэй.

6.3. Барилга байгууламж, түүний бүрдэл хэсэг, хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгө болон хүрээлэн буй орчны аюулгүй байдалд нөлөөлж болзошгүй барилгын материал, бүтээгдэхүүний шинж чанар, ашиглалтын нөхцөлийг техникийн дүгнэлтээр үнэлж, шаардлагатай тохиолдолд энэхүү дүгнэлтийг үндэслэн нийлүүлэгчийн мэдэгдэл эсвэл тохирлын гэрчилгээгээр баталгаажуулах бөгөөд дараах тохиолдолд техникийн дүгнэлт гаргуулна. Үүнд:

6.3.1. Барилгын материал, бүтээгдэхүүнд тавих шаардлагыг тогтоосон Монгол Улсын үндэсний стандарт байхгүй, эсхүл тухайн бүтээгдэхүүн гадаадын стандартаар үйлдвэрлэгдсэн;

6.3.2. шинээр боловсруулсан эсвэл шинэчлэгдсэн, техникийн үзүүлэлтүүдийн дагуу үйлдвэрлэсэн барилгын материал, бүтээгдэхүүний шинж чанар, хэрэглэх нөхцөл нь Монгол улсын нутаг дэвсгэрт хүчин төгөлдөр мөрдөж буй стандартаар бүрэн буюу хэсэгчлэн зохицуулагдаагүй.

6.4. Энэ техникийн зохицуулалтын 6.3-т дурдсан техникийн дүгнэлтийг Барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага гаргана.

6.5. Барилгын материал, бүтээгдэхүүн үйлдвэрлэгч, түүний итгэмжлэгдсэн төлөөлөгч болон импортлогч нь энэхүү техникийн зохицуулалтын аюулгүй байдлын шаардлагад нийцэж буйг баталгаажуулсан баримт бичигтэй байна. Үүнд:

6.5.1. Барилгын материал, бүтээгдэхүүний нийлүүлэгчийн мэдэгдэл эсвэл тохирлын гэрчилгээ;

6.5.2. Энэхүү техникийн зохицуулалт болон холбогдох техникийн норматив, эрх зүйн актуудад тусгасан аюулгүй байдлын шаардлагад нийцэж байгаа эсэхийг баталгаажуулах зорилгоор барилгын материал, бүтээгдэхүүний дээжид хийсэн анхдагч стандарт туршилтын тэмдэглэл;

6.5.3. үйлдвэрлэлийн хяналтын тогтолцоог баталгаажуулсан баримт бичиг (хэрэглэх тохиолдолд);

6.5.4. Шаардлагатай бол барилгын материал, бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд ашигласан материал, түүхий эдийн тохирлын гэрчилгээ эсвэл нийлүүлэгчийн мэдэгдэл;

6.5.5. Чанарын удирдлагын тогтолцоог нэвтрүүлж байгаа болон нэвтрүүлсэн эсэхийг баримт бичиг эсвэл хуулбар.

6.6. Техникийн дүгнэлт гаргах эрх бүхий байгууллага нь:

6.6.1. Аюулгүй байдал, чанарын үзүүлэлтийн утгыг тодорхойлохын тулд барилгын материал, бүтээгдэхүүний дээжийг турших ажлыг зохион байгуулна;

6.6.2. Энэхүү техникийн зохицуулалтын аюулгүй байдлын зайлшгүй шаардлагуудыг хангах барилгын материал, бүтээгдэхүүний аюулгүй байдал, чанарын үзүүлэлтүүдийн бодит утгыг тогтооно;

6.6.3. Барилгын материал, бүтээгдэхүүний техникийн баримт бичгийн үнэлгээ болон туршилтын үр дүнд үндэслэн хэрэглэх хүрээ, нөхцлийг тодорхойлно.

6.7. Барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь барилгын материал, бүтээгдэхүүнийг үйлдвэрлэгч, нийлүүлэгчийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлж, шинэчлэлт хийж хэрэглэгчдийг шаардлагатай мэдээ, мэдээллээр хангана.

6.8. Тохирлын гэрчилгээ авсан барилгын материал, бүтээгдэхүүний мэдээллийг салбарын баталгаажуулалтын байгууллага нь Барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад ирүүлж мэдээллийн санд заавал оруулсан байна.

6.9. Үйлдвэрлэгч болон түүний итгэмжлэгдсэн төлөөлөгч нь техникийн баримт бичгийн иж бүрдлийг барилгын материал, бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг бүрэн зогсоосон өдрөөс хойш арав хүртэл жил, импортлогч нь тухайн барилгын материал, бүтээгдэхүүнийг зах зээлд нийлүүлсэн өдрөөс хойш дор хаяж таван жил хадгална. Эдгээр баримт бичгийг холбогдох төрийн хяналтын байгууллага шаардсан тохиолдолд танилцуулна.

7 дугаар зүйл. Барилгын материал, бүтээгдэхүүний сав баглаа, боодол, хаяг, шошгожуулалт

7.1. Хаяг, шошгыг барилгын материал, бүтээгдэхүүнийг зах зээлд нийлүүлэхээс өмнө энгийн, ойлгомжтой, байдлаар дүрслэн, ашиглалтын хугацаанд арилахгүй, тод харагдахуйцаар тэмдэглэнэ.

7.2. Барилгын материалыг хадгалах, тээвэрлэх, нийлүүлэх, хэрэглэх үед үүсэж болох эрсдэл, аюултай болохыг мэдээллэх тэмдэг, тэмдэглэгээг сав, баглаа боодол, дагалдах баримт бичиг, танилцуулгад урьдчилан сэргийлэх зорилгоор анхааруулсан байна.

7.3. Барилгын материалын шошго, дагалдах баримт бичиг, танилцуулгад худалдан авагчдыг төөрөгдөлд хүргэж болзошгүй хоёрдмол утгатай мэдээллийг зааж оруулахыг хориглоно.

7.4. Барилгын материал, түүхий эд, бүтээгдэхүүний шошгод тухайн материал, бүтээгдэхүүний шинж чанар (шатамхай, дэгдэмхий, исэлдүүлэгч)-ыг нарийвчлан тусгана.

7.5. Дараах тохиолдолд буруу хаягласан гэж үзнэ:

7.5.1. шошго нь дутуу буюу худал мэдээлэл агуулсан;

7.5.2. тухайн материал, бүтээгдэхүүнийг өөр оноосон нэр, төрлөөр бичсэн;

7.5.3. өөр нэр, төрлийн материал, бүтээгдэхүүний сав, баглаа, боодол ашигласан, шошгыг хуурамчаар үйлдсэн;

7.5.4. Монгол Улсад болон олон улсад хэрэглэдэг тэмдэг, тэмдэглэгээг шошгод тавиагүй;

7.5.5. унших боломжгүй, ойлгомжгүй үг, хэллэг, огноо бичсэн.

БҮЛЭГ 4. ХАРИУЦЛАГА, БУЦААН ТАТАЛТ БА ХОРИГЛОЛТ

8 дугаар зүйл. Хариуцлага, хориглолт ба буцаан таталтын нөхцөл

8.1. Барилгын материал, бүтээгдэхүүн үйлдвэрлэгч, түүний итгэмжлэгдсэн төлөөлөгч, импортлогч нь материалын аюулгүй байдлыг хангах, хүний эрүүл мэнд, хүрээлэн буй орчин, экосистемийн аюулгүй болон тэнцвэрт байдалд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, урьдчилан сэргийлэх нөхцлийг бүрдүүлэх үүрэгтэй.

8.2. Үйлдвэрлэгч, түүний итгэмжлэгдсэн төлөөлөгч, импортлогч нь зах зээлд нийлүүлсэн барилгын материал, бүтээгдэхүүн нь энэхүү техникийн зохицуулалтын шаардлагыг хангаагүй тохиолдолд холбогдох хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээнэ.

8.3. Энэ техникийн зохицуулалтад заасан аюулгүй байдал, ханган нийлүүлэлтийн шаардлагыг зөрчиж, эрсдэл гаргасан болон хэрэглэх хугацаа дууссан барилгын материалыг хэрэглэх, хилээр нэвтрүүлэхийг хориглоно.

8.4. Зах зээл дээр нийлүүлсэн барилгын материал, бүтээгдэхүүний шинж чанар, аюулгүй байдлын үзүүлэлт өөрчлөгдсөн тохиолдолд барилгын материал үйлдвэрлэгч, нийлүүлэгч нь энэ талаар 72 цагийн дотор хэрэглэгчдэд мэдэгдэж, яаралтай залруулах бөгөөд 15 хоногийн дотор буцаан татах арга хэмжээг авна.

8.5. Дараах нөхцөлд барилгын материал, бүтээгдэхүүнийг ханган нийлүүлэлтийн сүлжээнээс буцааж татна.

8.5.1. хэрэглэсэн түүхий эд болон үйлдвэрлэж нийлүүлсэн материал нь хүний эрүүл мэнд, хүрээлэн буй орчин, экосистемийн тэнцвэрт болон аюулгүй байдалд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй гэж үзвэл;

8.5.2. тухайн барилгын материал, бүтээгдэхүүнээс шалтгаалан хүний эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд сөрөг нөлөө илэрсэн нь тогтоогдсон;

8.5.3. импортолсон болон экспортолсон барилгын материалын аюултай байдлын талаарх сэрэмжлүүлгийг хяналт, шалгалтын асуудал хариуцсан эрх бүхий байгууллагын олон улсын мэдээллийн сүлжээгээр мэдээлсэн;

8.5.4. Тухайн материал нь эрүүл ахуйн болон аюулгүй байдлын шаардлагыг хангаагүй, чанаргүй материал болохыг нь хяналт шалгалтаар тогтоосон.

8.6. Хүний эрүүл мэнд, хүрээлэн буй орчин, экосистемийн тэнцвэрт болон аюулгүй байдалд нөлөөлж болзошгүй, гарал үүсэл нь тодорхойгүй барилгын материалыг устгах үйл ажиллагааг Барилга, хот байгуулалтын сайдын 2020 оны 48 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Барилгын хог хаягдлыг цэвэрлэх, цуглуулах, ангилах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах журам”-аар зохицуулна.

8.7. Аюулгүй байдлын шаардлага хангаагүй барилгын материал, бүтээгдэхүүнийг зах зээлд нийлүүлсэн, буцаан татах арга хэмжээг хэрэгжүүлсэнтэй холбогдон гарсан зардал, лабораторийн шинжилгээний төлбөр, бусдад учирсан хохирлыг буруутай нь тогтоогдсон үйлдвэрлэгч, нийлүүлэгч хариуцна.

8.8. Техникийн зохицуулалтын шаардлагыг зөрчсөн зөрчлийн дагуу захиргааны шийтгэл ногдуулсан нь буруутай этгээдийг учруулсан хохирлоо нөхөн төлөх үүргээс чөлөөлөх үндэслэл болохгүй.

8.9. Барилгын материал, бүтээгдэхүүнийг үйлдвэрлэгч, түүний итгэмжлэгдсэн төлөөлөгч, импортлогч нь дараах үйлдэл хийхийг хориглоно. Үүнд:

8.9.1. Хүний эрүүл мэнд, хүрээлэн буй орчин, экосистемийн тэнцвэр болон аюулгүй байдалд нөлөөлж болзошгүй, гарал үүсэл нь тодорхойгүй барилгын материал, бүтээгдэхүүнийг зах зээлд нийлүүлэх;

8.9.2. Хяналт шалгалт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллага үйл ажиллагааг нь түр болон бүрмөсөн зогсоосон тохиолдолд үйл ажиллагаа явуулах.

БҮЛЭГ 5. ХЭРЭГЖИЛТЭД ТАВИХ ХЯНАЛТ ШАЛГАЛТ

9 дүгээр зүйл. Хэрэгжилт, хяналт шалгалтын зохицуулалт

9.1. Энэхүү техникийн зохицуулалтын хэрэгжилтийг улсын хэмжээнд Засгийн газар болон Төрийн хяналт шалгалтын тухай хуульд заасан эрх бүхий байгууллага хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавина.

9.2. Барилгын материал, бүтээгдэхүүнийг зах зээлд нийлүүлснээс хойших үе шатанд техникийн зохицуулалтын хэрэгжилтийн хяналтыг эрх бүхий улсын байцаагч хэрэгжүүлнэ. Улсын байцаагч нь хүний эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчин, нийтийн ашиг сонирхолд хохирол учруулж болзошгүй барилгын материал, бүтээгдэхүүний тохирлын баталгаатай эсэхэд хяналт тавина.

9.3. Импорт, экспортын барилгын материал нь Монгол улсаас олон улс, бүс нутгийн байгууллага, худалдааны түнш орнуудтай байгуулсан гэрээ хэлэлцээрээр тохирсон тохирлын болон түүнтэй адилтгах тэмдэг, гарал үүслийн гэрчилгээтэй байна.

9.4. Импорт, экспортын барилгын материалын чанар, аюулгүй байдлын шаардлагыг гаалийн болон чөлөөт бүсэд байрлах барилгын материалын итгэмжлэгдсэн лабораторийн тогтмол хяналт, мэргэжлийн хөндлөнгийн итгэмжлэгдсэн лабораторийн магадлан, шалгалтаар хангуулна.

9.5. Импортлох болон экспортлох барилгын материал, бүтээгдэхүүний аюулгүй байдалд улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хуульд заасны дагуу эрх бүхий улсын байцаагч хяналт тавина.

БҮЛЭГ 6. ШИЛЖИЛТИЙН ЗОХИЦУУЛАЛТ

10 дугаар зүйл. Шилжилтийн зохицуулалт

10.1. Энэхүү техникийн зохицуулалтыг үйлчилж эхлэхээс өмнө Монгол Улсын нутаг дэвсгэр дээр барилгын материал, бүтээгдэхүүнд олгосон Тохирлын гэрчилгээний үйлчлэлийн хугацааг дуусах хүртэл хүчинтэйд тооцно.

---oOo---